



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/61

Бор-Өндөр сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2026 онд хийгдэх “Ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж худалдан авах ” ажлын санхүүжилтийн үлдэгдэл болох 5,940,000 (таван сая есөн зуун дөчин мянга) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

2.Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу зарцуулахыг санхүүгийн албаны дарга /Э.Тувшинсайхан/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ